



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 482

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоол, 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Ланд круйзер 200 маркын 4489 УБҮ улсын дугаартай, 2011 онд үйлдвэрлэсэн, 90,909,090.00 (Ерэн сая есөн зуун есөн мянга ерэн төгрөг) төгрөгийн балансын үнэтэй, 73,691,322.54 (Далан гурван сая зургаан зуун ерэн нэгэн мянга гурван зуун хорин хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө) хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-д балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001253

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн
482-дугаар тогтоолын хавсралт

"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашиныг
"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-д балансаас балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг
1	Ланд крузер 200, 44-89 УБҮ, суудлын, арал: JTMDU09J7B4041836	2011/2012	134800	90,909,090.00	73,691,322.54	17,217,767.46
Нийт дүн						
				90,909,090.00 (Ерэн сая есөн зуун есөн мянга ерэн төгрөг)	73,691,322.54 (Далан гурван сая зургаан зуун ерэн нэгэн мянга гурван зуун хорин хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө)	17,217,767.46 (Арван долоон сая хоёр зуун арван долоон мянга долоон зуун жаран долоон төгрөг дочин зургаан мөнгө)